

Overview and rationale

<p>Үзүүлэлт</p>	<p>19. Олон нийтэд мэдээлэл өгөх арга хэмжээ нь СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх ойлголтыг нэмэгдүүлж, харилцан ойлголцол, харилцан хүндэтгэлийг бий болгодог эсэх.</p>	
<p>Үнэлгээний хүчин зүйлүүд</p>	<p>Энэхүү үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайланг үндэсний түвшний дөрвөн хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>19.1 СББӨ-ийн дадлагажигч, өвлөн уламжлагч нар нь бодлого, хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.</p>	<p>OD 105(d)</p>
	<p>19.2 СББӨ, түүний ач холбогдол, хамгаалалт болон Конвенцийн талаархи олон нийтийн арга хэмжээг олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс, олон нийт, судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад сонирхогч талуудад зориулан зохион байгуулдаг.</p>	<p>OD 105(b)</p>
	<p>19.3 Хамгаалалт хийхэд шаардагдах сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрүүд нь хөхүүлэн дэмждэгддэг.</p>	<p>OD 106</p>
	<p>19.4 СББӨ-ийн талаарх олон нийтэд түгээгддэг мэдээлэл нь олон нийт, бүлгүүдийн доторх болон хоорондын харилцан хүндэтгэл, талархах байдлыг дэмждэг.</p>	<p>Зүйл 14(a)(i)</p>

<p>ТХЗ болон бусад холбогдох үзүүлэлтүүд</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд: Бүх шалгуур үзүүлэлтүүдийн нэгэн адил энэхүү үзүүлэлт нь ТХЗ-ын Зорилт 11.4 буюу "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, түүний хамгаалалтын хүчин чармайлтыг бэхжүүлэх"-ийг дэмжиж байдаг.</p> <p>Бусад үзүүлэлтүүдийн хамаарал: Энэхүү үзүүлэлт нь мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтэд мэдээлэх арга хэмжээний талаарх агуулга, зорилго, тэдгээрийн үр нөлөөг авч үздэг. Тэгэхээр энэ нь 17-р Үзүүлэлт буюу иймэрхүү арга хэмжээнд олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс нь идэвхтэй оролцох тухай болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүрэг ролийг харуулсан 18-р Шалгуур үзүүлэлтийг дэмжиж хэрэгжүүлж байна. Үзүүлэлт 20 нь эсрэгээрээ түүнийг хэрхэн гүйцэтгэж байгаатай холбоотой байж таарч байна. Бие биенээ хүндэтгэх, талархах асуудлыг 15, 16-р заалтуудад олон нийтэд түшиглэсэн хүчин чармайлт, хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн хүрээнд мөн тусгасан болно. Харин сайн хамгаалалтын туршлагын талаарх олон улсын мэдээлэл солилцох үзүүлэлтийг Үзүүлэлт 24-т оруулсан байна.</p>
<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>17, 18-р заалтуудын нэгэн адил Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь “соёлын биет бус өвийн ач холбогдлыг орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд сурталчлах, түүнийг харилцан үнэлэн, таниулах явдал” (1(с) зүйл).))юм. Энд онцолж буй анхаарлын төв нь орон нутгийн болон үндэсний хэмжээнд гаргаж буй аливаа хүчин чармайлт бөгөөд энэ нь оролцогч улс, хэвлэл мэдээллийн байгууллага эсвэл бусад оролцогчид аль нь шууд хэрэгжүүлж байгаагаас үл хамаарна. Мөн олон нийтэд мэдээлэх ийм арга хэмжээний тэргүүлэх чиглэл, зарчмуудыг хэрхэн хамгийн сайн хэрэгжүүлэх ёстойг үйл ажиллагааны удирдамж нь тодорхойлсон бөгөөд үүнд: өргөн хүрээний оролцоотойгоор, харилцан хүндэтгэл, талархлыг дэмжих зорилготой байх орсон байна. Харин эцэст нь 19 дүгээр зүйлийн үзэл санааны дагуу хамгаалах сайн туршлагыг дэмжихэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.</p>
<p>Гол нэр томъёо</p>	<ul style="list-style-type: none"> · Дадлагажигч, өвлөн уламжлагч нар · Бодлого · Олон нийт, бүлгүүд эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүс · Оролцогч талууд · Түгээлт

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

Хяналтын ашиг тус	<p>Хяналт-шинжилгээ хийх нь олон нийтэд мэдээлэл өгөх арга хэмжээ нь өөрийн зорилгодоо хэр хүрч байгаа болон хүссэн үр дүндээ хүрч байгаа эсэхийг тодорхойлоход тусална. Түүнчлэн хяналт шалгалт хийх нь тухайн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа нь дадлагажигч, үүрэг гүйцэтгэгчдийн ач холбогдлыг санамсартай бусаар үл тоомсорлож байгаа эсвэл харилцан хүндэтгэлийг дэмжих бус харин санамсаргүйгээр сулруулж байгаа эсэхийг төрд анхааруулах боломжийг бий болно. Харин дэлхий түвшинд хяналт хийх нь мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагаанд ашиглагдах амжилттай арга барилыг олж тогтоох боломжийг нээж өгч чадах бөгөөд хэрэв улс орнууд орон нутгийн болон үндэсний хэмжээнд хамгаалах сайн туршлагыг түгээж байгаа бол ийм сайн туршлагууд нь бусад улс орнуудад ч мөн урам зориг өгөх эх үүсвэр болж чадна.</p>
Мэдээллийн эх сурвалж, цуглуулга	<p>Үзүүлэлт 17-ын нэгэн адил мэдээллийн чухал эх сурвалжийг мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн салбарын хариуцсан байгууллагууд эзэмшиж болно. Хяналт-шинжилгээ, тайлагналд хамрагдсан хүмүүс өөрсдийн туршлага дээрээ үндэслэн арга хэмжээ, үр нөлөөний талаар мэдээлэх боломжтой. Хэрэв төр нь зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулах механизмтай бол мэдлэг дээшлүүлэхэд үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээллээр хангаж чадахуйц идэвхтэй оролцоотой төлөөлөгчдийг багтааж болно.</p> <p>Боломжит мэдээллийн эх сурвалжууд</p> <ul style="list-style-type: none">· Хэвлэн нийтлэх, тайлан, сурталчилгааны материалын цуглуулга· Мэдээллийн яам ба/эсвэл Харилцаа холбооны яамны вэбсайт, тайлан· Вэбсайт, блог, видео бүртгэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байршуулсан нийтлэлүүд· Сошиал медиа бүлгүүд болон нийгэмлэгүүд